

МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

А.Батцэцэг¹

Монгол улс ба БНХАУ нь 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд 1951 оноос худалдаа эдийн засгийн салбарт хамтран ажиллах болсон.

1949-1962 онуудад хоёр талын харилцаа шинээр төлөвшин амжилттай хөгжиж, энэ хугацаанд Найрамдал, харилцан туслалцах хамтын ажиллагааны тухай гэрээ, хилийн гэрээ, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр зэрэг хоёр орны харилцааны эрх зүйн үндэс суурийг тавьсан олон гэрээ, хэлэлцээр байгуулсан. Өнөөдөр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлуудыг зохицуулсан 100 гаруй гэрээ, хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж байна. Монгол, Хятадын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр тогтвортой хөгжиж байна.

БНХАУ нь манай улсын хамгийн том худалдааны түнш юм². 2010 онд хоёр орны худалдааны эргэлт 3.3 тэрбум ам.доллар болсон бөгөөд үүнээс экспорт 2.4 тэрбум ам.доллар, импорт 985.5 сая ам.доллар болсон байна³. Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг Хятад улс сүүлийн 10 жил тэргүүлж байна. 1990-2010 оны байдлаар Монгол улсад БНХАУ-ын 2,468,235,000 ам.долларын хөрөнгө оруулалттай 5303 компани бүртгэгдсэн байна.

Хоёр талын өндөр дээд хэмжээний айлчлалууд, Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаан, дэд комиссын хуралдаанууд хоёр орны худалдаа эдийн засгийн салбарт чухал үүрэг гүйцэтгэж байна. Эдгээрээс 2010 онд байгуулагдсан “Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн форум” нь энэ салбарын хувьд ихээхэн чухал юм⁴. Энэхүү форумыг Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын урилгаар БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябаогийн Монгол улсад хийсэн айлчлалын хүрээнд зохион байгуулсан юм. Энэхүү форум нь уул уурхай, дэд бүтэц, хүнс хөдөө аж ахуй, банк санхүүгийн салбарын хүрээнд Монгол улсын хөрөнгө оруулалт, бизнесийн боломжийг БНХАУ-ын бизнес эрхлэгчдэд сурталчилан таниулах, хоёр орны бизнес эрхлэгчдийг холбож бизнесийн түншлэл тогтоон цаашид хамтран ажиллах боломж олгоход чиглэгдсэн юм.

2011 оны 2 дугаар сарын 24-25-нд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ян Жэчи манай оронд албан ёсны айлчлал хийх үеэр хоёр талын харилцааны түвшинг стратегийн түншлэлийн түвшинд гаргах асуудлыг хэлэлцэж зарчмын тохиролцоонд хүрснээр хоёр орны худалдаа эдийн засгийн

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

² Монгол Хятадын харилцаа “жаранаас жаранд”

³ “90 оноос хойшхи Монгол Хятадын харилцаа”

⁴ www.news.mn

салбарт илүү их ахиц гарч байна⁵.

Хоёр улсын худалдааны гол нэрийн бараа бүтээгдэхүүн

Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний 80-90 хувийг мал аж ахуйн болон байгалийн гаралтай түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн эзэлж байна. Харин хятад улсаас гол төлөв хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, барилгын материал импортлон авч байна⁶.

2008 оны байдлаар Хятад улсад экспортлосон байгалийн гаралтай түүхий эдийн хувьд авч үзвэл зэсийн баяжмал 93.1 хувь, молибдены баяжмал 97.4 хувь, самнасан ноолуурын 46.7 хувь, бог, бод малын арьс ширний дийлэнхийг Хятад улс руу экспортлосон байна⁷.

2000 оноос өмнө манай хоёр улсын худалдааны хувьд ахуйн хэрэглээний болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн голлож байсан бол, өдгөө уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн болох нүүрс, металл, нефть зэрэг ашигт малтмалын эзлэх хувь ихсэж байгааг Хятадын төв хэвлэл болох Жиньминь Жибао сонинд мэдээлсэн байна. Монгол, Хятад улс 4600 км-ээр хиллэдэг бөгөөд нийт арав гаруй хилийн боомттойгоос ихэнх ӨМӨЗО-ны нутагт байдаг ажээ. Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр 2010 оны 1-4-р сард манай улс ӨМӨЗО-той 920 сая ам.долларын худалдаа хийсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 140 гаруй хувиар өсчээ. Монгол, Хятадын нийт ачаа тээврийн 70 хувь нь Эрээн хотын боомтод ногддог бөгөөд үүгээр тээвэрлэгдсэн ачааны эргэлт 700 сая долларас 2,1 тэрбум доллар болж нэмэгдсэн байна.

БНХАУ зэсийн баяжмал, молибдены хүдэр, баяжмал, алтны хүдэр ба баяжмал, боловсруулаагүй алтанд тавих импортын барааны тариф нь тэг байгаа нь Хятадын эдгээр уул уурхайн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байгааг нь харуулж байна. Дээрх бүтээгдэхүүнүүд нь манай орноос Хятадад экспортлодог ашигт малтмал юм.

Харин манай улсаас экспортлодог бусад бараа бүтээгдэхүүн, ихэвчлэн хөдөө аж ахуйн бараанд тавих импортын тариф өндөр байна.

Хөрөнгө оруулалт

Хятад улсаас манай улсад оруулах хөрөнгө оруулалт жил ирэх тутам нэмэгдэж байна. 2005 оны байдлаар Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай 988 компани шинээр бүртгэгдэж 311 сая ам.долларын хөрөнгө оруулсан байна. Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг Хятад улс тэргүүлсэн хэвээр бөгөөд 1990-2005 онд өссөн дүнгээр Монгол улсад Хятадын 2131 аж ахуйн нэгж 682.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Энэ нь манай нийт хөрөнгө оруулалтын 30 гаруй хувийг эзэлж байна.

Дээрх хөрөнгө оруулалтын 68.6 хувийг геологи уул уурхай, 24.2 хувийг худалдаа нийтийн хоол, үлдсэн 7.2 хувийг бусад салбар тус тус эзэлж байна⁸. Монгол улсад БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар Сүхбаатар аймгийн Төмөртэйн овооны цайрын, Сэлэнгэ аймгийн Төмөртэйн төмрийн хүдрийн, Өмнөговь аймгийн Нарийнсухайтын нүүрсний зэрэг ордуудыг ашиглах, мөн мянганы зам болон нефть хайгуулын ажилд Хятадын сонирхсон аж ахуйн нэгж, байгууллагууд

⁵ mfat.gov.mn гадаад харилцааны яам

⁶ Монгол Хятадын харилцаа жаранаас жаранд

⁷ Монгол Хятадын харилцаа жаранаас жаранд

⁸ mongoliantrade.mn

идэвхтэй оролцох зэргээр хамтран ажиллаж эхлээд байна⁹.

Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтанд Хятад улсын эзлэх хувь
1990-2004 /мянган ам.доллар/

Жил	Нийт дун	Хятад улс	Эзлэх хувь
1990	965	865	89,6
1991	2,108	100	4,7
1992	1,906	593	31,1
1993	3,426	1,381	40,3
1994	11,153	2,228	20,0
п1995	38,611	3,159	8,2
1996	53,635	5,257	9,8
1997	40,824	9,358	22,9
1998	45,920	24,673	53,7
1999	86,865	22,192	25,5
2000	93,707	33,011	35,2
2001	122,761	47,529	38,7
2002	174,820	135,344	77,4
2003	196,821	45,370	23,1
2004,9	205827	116120	56,4
Нийтдүн	1,193,696	453,808	38,0

Эх сурвалж: Mongoliantrad.mn

Монгол улс БНХАУ-ын банк, санүүгийн хамтын ажиллагаа

Хятад улс нь Монгол улсын худалдааны хамгийн том түнш бөгөөд Монгол Хятад хоёр орны худалдаа эдийн засаг, банк санхүү зэрэг салбарт хамтын ажиллагаа өргөжсөөр байна.

2011 оны 5 дугаар сард БНХАУ-ын Ардын банкны ерөнхийлөгч Жоу Сяочуань Монгол улсад хүрэлцэн ирж хоёр орны хооронд чухалд тооцогдох гэрээг байгуулсан. Тэрээр хоёр улсын үндэсний валютын харилцан солилцох своп гэрээнд гарын үсэг зурсан нь Хятад улстай төгрөгөөр худалдаа хийх боломж нээсэн гурван талын ач холбогдолтой гэрээ болсон юм.

Нэгдүгээрт, аливаа хямралын үе мөн гадаад төлбөр тооцоонд хүндрэл гарсан тохиолдолд нөөц валютаар төлбөр тооцоо хийлгүй, төгрөгөөр юань худалдаж аван Хятадтай гадаад худалдааны төлбөр хийх давуу талыг олгож байна.

Хоёрдугаарт, хоёр улс хоорондын гадаад худалдааг Хятадын талаас Монголын талд төгрөгөөр, харин Монголын тал Хятадын талд юаниар төлбөр тооцоогоо хийх боломж нээгдсэн.

Гуравдугаарт, Хятадын юань Монголын нутаг дэвсгэр дээр харьцангуй чөлөөтэй хэрэглэдэг хэдий ч өнөөдөр монгол төгрөгийг Хятадад хүлээн зөвшөөрүүлэх боломж гарч ирж байгаа ач холбогдолтой юм. Энэхүү гэрээг гурван жилийн хугацаатай байгуулсан бөгөөд таван тэрбум юаньтай тэнцэх хэмжээний үндэсний валютыг харилцан солилцохоор тохиролцсон. Гэрээний

⁹ mongoliantrade.mn

хугацааг дуусах болоход сунгах нөхцөлтэйгээр байгуулсан. Мөн түүний энэхүү айлчлалаар сүүлийн хэдэн жилд тасалдаад байсан Монгол Хятадын арилжааны банкны захирлуудын хоёр улсын хоорондох банк санхүүгийн харилцааны тулгамдсан бэрхшээлтэй асуудлаа шийддэг дугуй ширээний уулзалтыг 2011 ондоо багтаан зохион байгуулахаар тохиролцсон.

Дүгнэлт

Монгол Улс нь БНХАУ-тай харилцах найрсаг, сайн хөршийн харилцааг урт хугацаанд хөгжүүлж, харилцан ашигтай, эрх тэгш хамтын ажиллагааг өргөжүүлэхийг эрхэмлэн гадаад бодлогынхоо тэргүүлэх ач холбогдолтой чиглэл гэж үздэг. Сүүлийн жилүүдэд хоёр талын бүс нутаг, аймаг, мужууд болон салбар хоорондын шууд хамтын ажиллагаа идэвхжиж, худалдаа, эдийн засгийн харилцаа улам өргөжиж байна. Үүнд хоёр талын өндөр дээд хэмжээний айлчлалууд, ЗГХК-ын ээлжит хуралдаан, дэд комиссын хуралдаанууд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол улс хоёр том хөрштэйгээ харилцах харилцаандаа өндөр ач холбогдол өгдөг бөгөөд Хятад улсын Монгол улсын эдийн засагт үзүүлэх нөлөө их юм. БНХАУ нь том зах зээл бүхий Монгол улсын худалдааны гол түнш юм. Хэдийгээр манай орон Хятад улстай

хийсэн худалдаанаас ашиг хүртэж байгаа боловч Хятад улсаас импортлож буй бараа бүтээгдэхүүний нийт хэмжээ нь 2009 оны байдлаар манай нийт импортын хэмжээний 25 хувийг дангаараа бүрдүүлж байна. Харин Хятад улс руу экспортлож буй бараа бүтээгдэхүүн Монгол улсын нийт экспортын хэмжээний 74 хувийг дангаараа бүрдүүлж байна. Эдгээр үзүүлэлт нь Монгол улс гадаад худалдааны хувьд БНХАУ-аас хамаарал ихтэй байгааг харуулж байна. Монгол улс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа аль нэг оронд эдийн засаг, улс төр гэх мэт аль ч салбарт давуу байдлыг олгохгүй хэмээн тусгасан боловч одоогийн байдлаар манай улсын импортоор авч буй өргөн хэрэглээний бараа, манай орны экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн Хятад улсаас ерөнхийдөө хамааралтай байна.

Монголын экспортод уул уурхайн салбарын нөлөө улам хүчтэй болж ойрын ирээдүйд уул уурхайн салбартай өрсөдөх шинэ салбар үйлдвэрлэл гарч ирэх магадлал бага байна. Иймээс Монгол улс Хятад улстай уул уурхай, дэд бүтийн салбарт хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллах сонирхолтой байгаа.

2010 онд Хятадын Ерөнхий сайд ВэньЗябаогийн айлчлалын үеэр энэ асуудлыг мөн хөндөн ярилцсан. Тухайн үед Хятадын талаас Монгол Улсын дэд бүтцийг хөгжүүлэх, уул уурхайн салбарыг хөгжүүлэх асуудлаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах санал дэвшүүлж байв. Үүнийг Монголын тал дэмжиж, талархан хүлээж авч байгаагаа илэрхийлсэн.

Газарзүйн байрлалын хувьд хөрш зэргэлдээ оршдог гэдэг утгаараа Монгол Хятад хоёр улс хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд олон давуу талтай. Тиймээс бид энэ боломжоо ашиглаж, харилцаагаа сайжруулах, цаашлаад Монгол Улсын хөгжил, эдийн засгийн шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулах хүсэлтэй байгаа юм.

Хоёр орны хооронд уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний худалдаа ихэсч байна. Хятад улс бол нүүрсний хэрэглээгээрээ дэлхийд тэргүүлдэг орнуудын нэг. Иймээс Таван Толгойн нүүрсний ордны үйл ажиллагааг явуулж эхлээд байгаа энэ үед манай улс Хятад улсын нүүрсний гол түнш болох боломж байна гэж үзэж байна. Гэхдээ зөвхөн уул уурхайн салбар гэлтгүй, өөр олон талын худалдааг дэмжих хэрэгтэй.

2011 оны 5 дугаарсард хоёр орны банк санхүүгийн хамтын ажиллагаанд чухал гэрээ байгуулагдсан нь валют харилцан солих хэлэлцээр юм. Энэхүү гэрээ байгуулагдсанаар аливаа хямралын үе мөн гадаад төлбөр тооцоонд хүндрэл гарсан тохиолдолд нөөц валютаар төлбөр тооцоо хийлгүй, төгрөгөөр юань худалдаж аван Хятадтай хийсэн гадаад худалдааны төлбөрөө хийх давуу талыг олгосон бөгөөд хоёр улс хоорондын гадаад худалдааг Хятадын талаас Монголын талд төгрөгөөр, харин Монголын тал Хятадын талд юаниар төлбөр тооцоогоо хийж боломж нээгдсэн чухал ач холбогдолтой гэрээ төдийгүй хоёр орны Төв банк хоорондын хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлснийг харуулсан юм.

Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Хятадын Тяньжин хотын далайн боомтод тээвэр, зуучийн цогц үйлчилгээний төв байгуулахаар яриа, хэлэлцээг эхлүүлээд байна. Энэ нь дамжин өнгөрүүлэх тээврийн асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэхээс гадна манай хоёр орны эдийн засагт чухал ач холбогдолтой гэж үзэж байна.